



## ХЭНТИЙ АЙМГИЙН БОР-ӨНДӨР СУМЫН “БОР-ӨНДӨР” БАГА СУРГУУЛИЙН ЗАХИРЛЫН ТУШААЛ

2023 оны 12 сарын 18 өдөр

Дугаар А/11

Бор-Өндөр

┌ Суралцагчдын аюулгүй байдлыг хангах тухай ┐

Монгол Улсын Боловсролын ерөнхий хуулийн 33 дугаар зүйлийн 33.3.1, Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2023 оны А/554 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. 2023-2024 оны хичээлийн жилийн хоёрдугаар улирлын танхимын хичээл, сургалтыг зайн, цахим хэлбэрээр зохион байгуулсантай холбогдуулан хүүхдийг гэр бүлийн орчинд хараа хяналтгүй орхихгүй байх, эрүүл, аюулгүй байдлыг хангах, болзошгүй эрсдэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх талаар эцэг эх, асран хамгаалагчид зөвлөгөө, зөвлөмж хүргэж, суралцагчдын аюулгүй байдлыг хангасугай.

2. Малчин өрхийн сурагчдыг 2023 оны 12 дугаар сарын 29-ний өдрөөс эцэг эх, асран хамгаалагчдад гараас гарт хүлээлгэн өгсүгэй.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг сургалтын менежер (М.Нармандах), нийгмийн ажилтан (Э.Нарантуяа), анги удирдсан багш нарт тус тус үүрэг болгосугай.

ЗАХИРЛЫН АЛБАН ҮҮРГИЙГ  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Ч.АМАРЖАРГАЛ